



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/336

Чингис хот

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 29.1.6-ын "а", 29.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2021 оны А/155 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэл бүхий Галшар, Баянмөнх, Дэлгэрхаан, Бор-Өндөр сумдын нутаг дэвсгэр дэх мэдрэмтгий мал сүргийг бүрэн дархлаажуулах ажлыг 7 дугаар сарын 05-ны өдрөөс 15 хоногийн дотор зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын арга хэмжээг батлагдсан хуваарийн дагуу, технологит хугацаанд нь шуурхай зохион байгуулж Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн, багийн Засаг дарга нарыг томилон ажиллуулах, хүн хүчээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар, журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч нарт хариуцуулсугай.

4. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

221011722